

2

ТА ӨРӨНД ОРОХГҮЙН ТУЛД ЮУ ХИЙХ ЁСТОЙ ВЭ?

Ерөнхий санамж

- Өөрт байгаа хурааж хуримтлуулсан бэлэн мөнгөөр худалдан авалт хийгээрэй. Хэрвээ танд зээл хэрэгтэй бол энэ тухай өөрийн үйлчлүүлдэг банкандаа мэдэгдэх эсвэл бусад банкуудын зээлийн нөхцлүүдийг харьцуулж үзээрэй.
- Та өөрийн бодит орлого зарлагаа шалгаж аль болох тэнцвэрт байдлыг хангаарай. Боломжтой бол шаардлагатай гэнэтийн зардалд хэрэглэх мөнгө хадгалаарай.
- Орлого цалинтай холбоотой бүх бичиг цаасыг хадгалаарай. Хэзээ ч жинхэнэ гэрээг хэнд ч өгч болохгүй.
- **Гүйцэд сайн бүгдийг ойлгохгүй байгаа зээлийн тухай гэрээн дээр гарын үсгээ зурч болохгүй!** Орчуулагч дуудан эсвэл түүний хуулбарыг уншихаар аваарай. Хэдэн арван хуудас гэрээ атлаа зарим зүйлийг цөөхөн үгээр ойлгомжгүй эсвэл жижиг үсгээр бичсэн гэрээг зөвшөөрч гарын үсгээ зурахгүй байсан нь дээр! Иймэрхүү гэрээ нь голдуу банк бус санхүүгийн байгууллагын гэрээ байхаас эдгээрийн нөхцөл нь ойлгомжтой юм шиг санагдавч үр дүн нь дэндүү эрсдэлтэй байдаг.
- Өмнөх зээлээ төлөхийн тулд дараагийн зээлийг авахгүй байхыг хичээх хэрэгтэй, аргагүй байдалд ороод дахин зээлсэн ч цаашид давхар хүү төлөх нь илүү хүндрэлтэй болно. Зарим нэг банк нэгтгэсэн буюу конселданци зээл олгодог энэ нь зээлүүдээ нэгтгээд нэг зээл аваад урт хугацаагаар эргүүлэн төлнө гэсэн утгатай.
- Зээлээр худалдан авалт хийх эсвэл зээл авах эсэхээ аль болох бодож байж шийдвэр гаргаарай.
- ЧУ-д иргэдийн санхүүгийн асуудлаар далимдуулан ашиг олдог компаниуд байдаг. Зээлийн саналууд мөн зээлийн төлөлтийн шаардал, багахан хэмжээний өр зэргээр эдгээр компаниуд хялбархнаар мөнгө салгах үүсвэр болгож чаддаг!
- Хэрвээ танд ямар нэгэн санхүүгийн асуудал байвал та аль болох хугацаа алдалгүйгээр зээл олгогчтой ярилцаж шийдвэрлэхийг оролдоорой. Шүүхийн шийдвэрээр өр барагдуулагч нар танайд ирэхээс өмнө асуудлыг шийдвэрлэх олон арга зам танд байна. Шүүхээс шийдвэр гарсан хойно шийдвэрлэх нь танд илүү хохирлыг амсуулдаг.
- Ажлын зардал, торгууль, хугацаа хэтрэлтийн хүү торгууль, шүүхийн ажлын зардал эсвэл өр барагдуулагч нарын ажлын зардал үндсэн төлбөрөөс илүү болох талтай. Өр зээлийг бага хэмжээгээр эргүүлэн төлж эхэлж байгаа тохиолдолд юун түрүүнд хугацаа хэтрэлтийн хүү, торгуулийг төлөхгүй бол алданги хүү өссөөр байдаг тул **үндсэн өр огт багасдаггүй харин ч нэмэгдэж болно.**
- Албан захиа – тээвэрлэлт: та захиаг хүлээж **аваагүй байсан ч** (авахаар очоогүй, эсвэл гардаж авахаас татгалзсан) захиаг **хүлээж авсанд тооцон мөн хуулийн дагуух хариу илэрхийлэх хугацаа явсаар байдаг!**

Өр зээл, санхүүтэй холбоотой асуудлаар тусламж зөвлөгөөг Гадаад иргэдийг интегралчилах төвд ТББ (тодорхой мэдээллийг: www.cicpraha.org) хандаж болно. Эсвэл санхүүгийн асуудалд орсон хүмүүст зөвлөгөө өгөх байгууллагад хандаж болно:

Иргэдэд зөвлөгөө өгөх төв – <http://dluhj.obcanskeporadny.cz/>

Санхүүгийн хүнд нөхцөл дэх зөвлөгөө өгөх төв – www.financnitisen.cz

Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл: www.cicpraha.org/infoservis.

Өр зээлийн холбоотой асуудалуудын талаарх зөвлөмжийн эх сурвалж нь иргэдэд зөвлөгөө өгөх консорциумаас гаргасан материал болно (Asociace občanských poraden).

Мэдээллийн агуулга хэвлэгдсэн хугацаандаа хүчинтэй, шаардлагатай өөрчлөлтийг эсрэгүүцэх боломжгүй.



САНХҮҮГИЙН АСУУДАЛ – ТОЛЬ БИЧИГ

1

ТОЛЬ БИЧИГ- САНХҮҮГИЙН АСУУДЛЫГ ХЭРХЭН ОЙЛГОХ, ЮУГ МЭДЭЖ СОНССОН БАЙХ ЁСТОЙ

Зээлдэгчтэй этгээд (dlužník)	Бэлэн мөнгө эсвэл бараа бүтээгдэхүүн зээлээр авсан, эсвэл төлөх үүрэгтэй зүйлийг төлөөгүй байгаа этгээдийг хэлнэ.
Өр барагдуулгч (exekuce)	Хуулийн дагуу албадан өрийг төлүүлэхийг шаардсан шийдвэр (výkon právomocného rozhodnutí) юм. Үүнд эд хөрөнгийг битүүмжлэх, үнэ хаялцах худалдаагаар, зарах, бэлэн мөнгө, цалингийн тодорхой хувь зэргийг битүүмжилж болно.
Эд хөрөнгө битүүмжлэх шийдвэр (exekuční příkaz)	Хэрвээ танайд өр барагдуулагч ирвэл танд эд хөрөнгө битүүмжлэх шийдвэр (дугуй тамгатай), шүүхийн өр барагдуулах ажлыг хийх тухай шийдвэр гаргасан захирамжийг үзүүлэх ёстой.
Өр барагдуулах шийдвэр (exekuční titul)	Эд хөрөнгө хурааж болох хүчин төгөлдөр болсон шийдвэр. Иймэрхүү шийдвэрт төлбөрийн захирамж, шүүхийн шийдвэр, өр барагдуулагч эсвэл нотариатчтай үйлдсэн тэмдэглэл зэргээс гадна төрийн байгууллага болон орон нутгийн засаг захиргааны шийдвэр (rozhodnutí orgánů státní správy), татвар, эрүүл мэндийн даатгал, нийгмийн даатгалын төлбөр, шимтгэл болон бусад хураамжийн өр төлбөрийн хэмжээг тогтоосон тайланг тооцно.
Урт хугацааны зээл (hypotéka)	Үл хөдлөх хөрөнгө худалдан авахаар эсвэл байр сууцандаа засвар хийхээр, байшин барилга барихаар банкнаас авч буй урт хугацааны зээл.

Энэ танилцуулга гуравдагч орны иргэний интеграцад зориулан Европын сангаас дэмжлэг авсан төсөл юм.



MINISTERSTVO VNITRA
ČESKÉ REPUBLIKY

Дансны зээл _____ Банкнаас энгийн данснаас зээлж болох богино хугацаны зээл юм. Тухайн банкны *(kontokorent)* үйлчлүүлэгч дансан дах бэлэн мөнгө хангалтгүй тохиолдолд энэ зээлийг (kontokorentní úvěr) зээлж болдог. Банктай хийсэн гэрээнд заасан хэмжээгээр таны дансан дах мөнгө „хасах руугаа орсон“ үед төлбөрийн картаар дамжуулан зээлдэг. Төлбөрийн карт хэсгээс харна уу.

Хэт өндөр зээл _____ Зээлэнд дэндүү өндөр хүү тогтоох. Чех улсад хуулийн дагуу хэт өндөр хүү тогтоох нь гэмт *(lichva)* хэрэг байдаг.

Тайлбар _____ Төлбөрийн шийдвэрийн эсрэг гаргах эрх зүйн тайлбар. *(odpor)*

Өр барагдуулах үйл явц _____ Өрийн битүүмжлэлээс түр чөлөөлж шүүхийн хяналтын дор тодорхой нөхцөлтэйгээр өрөө *(osobní bankrot)* барагдуулах үйл явц.

Эрх хэмжээ _____ Шүүхийн шийдвэрт зээл олгогчийн эрхийг тодорхойлсон. *(oprávněný)*

Төлбөрийн Карт *(platební karty)*

Энгийн карт _____ зөвхөн дансанд байрлуулсан мөнгөөр гүйлгээ хийх эрхтэй байдаг. Дансан дах үлдэгдэл *(debetní platební karta)* хасах руу орвол гүйлгээ хийхийг хязгаарласан байдаг.

Кредит карт _____ энэ картаар дамжуулан зээл авч болдог. Картан дах үлдэгдэл „хасах руу орсон“ ч тодорхой *(kreditní platební karta)* хэмжээний мөнгийг тодорхой шатлалтайгаар буцааж төлөх гэрээ хийсний үндсэн дээр зээлч болдог.

Мөнгөн тэмдэгтийн хураамж _____ Төлбөрийг төлж барагдуулах ёстойг тогтоосон шийдвэр гаргахад гарсан ажлын зардал *(náklady řízení)* гол төлөв зээлдэгч төлдөг. Мөнгөн тэмдэгтийн хураамж дэндүү өндөр хэмжээтэй санагдаж байвал **үүний эсрэг шийдвэрт бичсэн хугацааны дотор тайлбар бичиж болно.**

Хугацаа хэтрэлтийн торгууль _____ Ерөнхийдөө хүүтэй төстэй бөгөөд төлөх хугацаандаа төлөөгүй тохиолдолд өдөр бүр нийт *(penále)* төлбөрөөс тооцож гаргах торгууль юм. Пенал гэх ойлголтыг ихэнхдээ төрийн байгууллагууд хэрэглэдэг: Эрүүл мэндийн, нийгмийн даатгалын газар. Та нийт төлбөрөө төлсний дараа торгуулиас чөлөөлөх хүсэлтээ гаргаж болох ба тухайн байгууллага таны шалтгаануудыг харгалзан үзээд торгуулиас чөлөөлөх эсэхээ шийддэг.

Төлбөрөө төлөх шийдвэр _____ Шүүх гомдол гаргагчийн өргөдлийн дагуу өртэй этгээдийг оролцуулалгүйгээр богино *(platební rozkaz)* хугацаанд гаргадаг шийдвэр -үүнд, төлбөрийн шийдвэрийг хүлээж авснаас 15 хоногийн дотор гомдол гаргагчид өрийг төлөх мөн үүнтэй холбоотой гарсан мөнгөн тэмдэгтийн хураамжийг төлж барагдуулахыг шаардсан байдаг: төлбөрийн шийдвэрийн эсрэг тайлбар **(odpor)** гаргаж болно.

Нийт төлбөр _____ Зээл олгогч зээл авсан этгээдээс буцаан төлөхийг шаардаж болох нийт төлбөр. Үндсэн *(pohledávka)* зээлнээс гадна хүү, алданги хүү, өр нэхэмжлэх явцын мөнгөн тэмдэгтийн хураамж зэрэг багтдаг.

Үүрэг _____ Зээлдэгч буюу мөнгийг хэрэглэсэн буцаан төлөх үүрэгтэй хүнд шүүх ажиллагааны тухай *(povinný)* мэдээллэсэн мэдэгдэл.

Хугацаа хэтрэлт _____ Эргэн төлөлттэй холбоотой хугацаа хэтрэлт: заасан үүрэгт хугацаандаа төлөөгүй байдал, *(prodlení)* Úroky z prodlení-ээс харна уу.

Гомдол гаргах аас өмнөх сануулага _____ Зээл олгогч зээлдэгчид зээлийн төлөлтийн талаарх сүүлийн үеийн мэдээлэл, хэдийг төлөх *(předzáložní upomínka)* үүрэгтэйг сануулсан санамж хэрвээ төлбөрөө хийхгүй тохиолдолд **шүүхэд өргөдөл өгөх** зэргийг агуулсан захиа.

Хамааралт төлбөрүүд _____ Шүүхийн шийдвэр дэх нийт төлбөрийг бүрдүүлсэн мөнгөн дүн. Энэ бүрдэлтэнд зээлийн *(příslušenství, „částka... Kč s příslušenstvím“)* хүү, хугацаа хэтрэлтийн хүү, шимтгэл, зээл олгогчийн өмгөөлөгчийн зардал. Бүрдэлт нь эцсийн дүн биш, үндсэн өрөө төлж барагдуулах хүртэл өссөөр байна. Өр барагдуулагчийн ажлын зардлыг сүүлд тусд нь тооцдог болохоор үүнд тооцогдоогүй байдаг.

Зээлдэгчийн бүртгэл _____ Өрөө барагдуулсан, өр төлбөртэй тухай бүртгэдэг ба энэ талаар мэдээлэл өгдөг *(registru dlužníků)* байгууллага.

Жилийн процентны шимтгэл _____ Зээл олгогчид төлөх ёстой бүх шимтгэл хураамж гэх мэт зээлийн татварт хамаарах зүйлс. *RPSN, roční procentní sazba nákladů*

Батлан даагч _____ Зээл хүсэгч ямар нэг шалтгааны улмаас төлбөрөө төлж чадахгүй болсон тохиолдолд түүний *(ručitel)* өмнөөс өрийг барагдуулна гэж зээлийн гэрээнд оролцож буй хүн.

Үнэт цаас _____ энэ нь тодорхой хэмжээний мөнгө төлнө гэсэн гарцаагүй амлалт илэрхийлсэн баримт юм. *(směnka)* Зээл авч байхад зарим зээлдүүлэгч байгууллага танаас векселээр баталгаа гаргахыг шаардах буюу өөрөөр хэлбэл зээл төлөгдөөгүй тохиолдолд вексел нь түүнийг төлөх баталгаа болно гэсэн үг. Вексельд гарын үсэг зурна гэдэг бол танд сөргөөр нөлөөлж болохоор хувирч чадах аюултай зүйл юм. Учир нь зээл олгогч шүүхэд таны гарын үсэг бүхий векселийг гаргасан тохиолдолд шүүх нэн даруй түүний шаардлагыг хангах шийдвэр гаргана. Шүүх таныг эрхтэй эсэх асуудлыг хэлэлцэхгүй орхиж, гагцхүү векселийн зөв бурууг хянана.

Төлбөрийн хуанли _____ Танд төлбөрийг төлөхөд бэрхшээл гарвал бага багаар тодорхой хугацаагаар төлөх *(splátkový kalendář)* хүсэлт гаргаж болдог. Зээл олгогчтой өрийг хэрхэн барагдуулах талаар яг хэдий хугацаанд, сар бүр тодорхой хэдийг төлөх тухай тохиролцож болдог. Энэ тохиролцоо нь анх байгуулсан гэрээний нөхцлөөс ялгаатай байж болно.

Цалингаас суутгах _____ Ажил олгогч шүүх, шүүхийн өр барагдуулагч, татварын албаны шийдвэрийн дагуу өртэй *(srážky ze mzdy)* этгээдийн цалингаас тодорхой хэсгийг суутгаж авч болно. Эд хөрөнгө битүүмжлэх тухай хуулинд заасны дагуу **битүүмжилж болохгүй доод хэмжээ хүртэл** цалингаас суутгаж болно.

Хамтран зээлдэгч _____ Өрийг хамтран төлөх үүрэг хүлээсэн хүн. Түүний хариуцлага „зээлдэгчтай“ ижил. *(spoludlužník)* Зээл олгогч үндсэн зээлдэгчид мэдэгдэж сануулалгүйгээр хамтран зээлдэгчээс өрийг гаргуулахыг шаардаж болно (түүний батлан даагч гэсэн утгатай).

Хэрэглээний зээл _____ Хувь хүнд хэрэглээний эд зүйлс, үйлчилгээ авахад зориулан олгодог зээл. Хэрэглээний зээл *(spotřebitelský úvěr)* ихэнхдээ 5000,- Кронгоос дээш байдаг.

Хаалт _____ Өрийн төлөлт бүхэлдээ эсвэл хэсэгчлэн багассан. *(umořeni)*

Санамж _____ Зээл олгогч зээлдэгчид төлбөрөө төлөөгүй үед өрөө барагдуулахыг шаардах хуудас. *(upomínka)*

Зээлийн хүү _____ Зээлнээс хувиар тооцох ашиг. Зээл олгогч зээлсэн мөнгөнөөсөө ашиг олох үүднээс, *(úrok z půjčky)* зээлдэгч мөнгөгийг ашигласны төлөө өгөх нэмэлт төлбөр.

Хугацаа хэтрэлтийн шимтгэл _____ Хуваарьт хугацаандаа төлбөрөө төлөөгүй тохиолдолд ирэх хугацаа хэтрэлтийн алданги *(úroky z prodlení)* хүү юм. Алданги хүү нь үндсэн хүүнээс өндөр байдаг. Голдуу зээлийн тухай гэрээ байгуулахад зээлийн нийт хэмжээнээс өдөр бүр алданги хүүг ямар хувиар тооцох тухай бичсэн байдаг. Хэрвээ гэрээнд алданги хүүний тухай тохиролцоогүй бол хуулин дах дээд хугацаагаар тооцдог.

Зээл _____ Тодорхой хугацаагаар эргэн төлөх үүрэгтэйгээр зээл олгогчоос зээлдэгчид үзүүлж буй *(úvěr)* санхүүгийн үйлчилгээ. Хуулиар заасан олон төрлийн зээл байдаг: хэрэглээний зээл, үл хөдлөх хөрөнгийн зээл, бизнесийн зээл.

Зээл олгогч _____ Зээлдэгчид мөнгө зээлж буй этгээд. Энэ нь хувь хүн, банк эсвэл банк бус санхүүгийн *(věřitel)* байгууллага байж болно.

Шийдвэрийн чадал _____ Ехекусе (дээр дурдсанаас харна уу). *(výkon rozhodnutí)*

Хасалт хийлгэх гомдол _____ Өр барагдуулагч эд хөрөнгө битүүмжилсэн жагсаалтанд таны төрөл садан эсвэл өөр *(vyučovací žaloba)* хэн нэгний эд хөрөнгийг битүүмжилсэн бол тухайн хүн битүүмжилсэн эд хөрөнгийн жагсаалтаас өөрийн эд зүйлсийг хасахыг хүссэн хүсэлтээ гаргах эрхтэй. Энэ тухай мэдсэнээсээ хойш 30 хоногийн дотор **хасалт хийх өргөдлөө** (vyučovací žalobou) гаргана.

Шаардах бичиг _____ Зээл олгогч зээлдэгчид өрөө төлөхийг буюу үүргээ биелүүлэхийг шаардсан шаардах *(výzva)* захиа. Энэ нь upomínka-тай адил утгатай юм.

Барьцаа _____ Зээлээ төлж чадахгүй нөхцөлд төлбөрийг барагдуулах баталгаа болгож эд хөрөнгөөр *(zástava)* баталгаа гаргадаг үүнд ихэнхдээ хөдлөх эсвэл үл хөдлөх хөрөнгө байдаг. Зээл олгогч гэрээ хийх үед зээлийг ямар нэг эрсдэлээс хамгаалж даатгалд хамруулж болно.